



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, МҮЕА-ын А/108 дугаар тушаалаар баталсан “Аудитын жилийн төлөвлөгөө”, МҮЕА-ын баталсан Ховд аймаг дахь ТАГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ХОВД АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ТАЙЛАНГ ХҮРГҮҮЛСЭН ЭТГЭЭД: Ховд аймгийн ИТХ-ын дарга, Ховд аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ: Ховд аймаг дахь Төрийн аудитын газар, холбоо барих утас 70433061

Дараах QR кодыг уншуулж дэлгэрэнгүй тайлантай танилцах боломжтой.

Ховд хот

2025.05.12

АУДИТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын хураангуй тайлангийн зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг ГНАГ, Аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын тайлагналын хэлбэр, зарчим, аудитад хамрагдсан байгууллага

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг ГНАГ, Аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх;
- Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан эсэх;
- Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан эсэх;

Аудитаар төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг төрийн бодлого боловсруулах. Төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг бүтэц, зохион байгуулалттай төрийн захиргааны, тусгай, үйлчилгээний байгууллагуудын хүний нөөцийн, бодлогын, хяналт шинжилгээ дотоод аудитын албад нь өөрийн болон өөрт хамаарах байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг оновчтой зөв тодорхойлсон, боловсруулсан, баталгаажуулсан байдлыг хамруулсан.

БҮЛЭГ 1. ЗАРИМ АЛБАН ТУШААЛТАН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

Төсөвт байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үр дүнтэй зохион байгуулаагүй, аймгийн Засаг дарга нь хууль зөрчин 2 орлогч даргатай ажиллаж байна

1.1.1 Ховд аймгийн хэмжээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэлд хамаарах 177 төсвийн шууд захирагч, 4 төрийн өмчит аж ахуйн нэгж, 9 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 ЗГ-ын тусгай сан, 36 орон нутгийн тусгай сан, 17 төсвийн төвлөрүүлэн захирагч, 1 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгтэй ажиллаж байна.

1.1.2 Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан Тэргүүн дэд, орлогч дарга ажиллуулсантай холбоотой 2024 онд 1 зөрчил илэрсэн нь 2024 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр аймгийн удирдлага солигдож Засаг дарга нь 2 орлогч даргатай ажилласан тул олгосон цалинг буцаан төлүүлэх төлбөрийн акт бичигджээ.

1.1.3 Зарим албан тушаалтан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар 5.2¹, 5.3² дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Аймгийн Засаг даргын 2024 оны Б/48 тоот захирамжаар аймгийн нийгмийн салбарын төсөл, хөтөлбөр хариуцсан удирдагч бөгөөд аймгийн Засаг даргын орлогчийг томилсон,
- Шинэ ховд баруун бүсийн хөгжлийн корпорац ААТҮГ нь 2024 онд зөвлөх гэсэн орон тоотой ажилласан,
- Шим-Ус ОНӨААТҮГ нь 2023, 2024 онуудад хуулийн зөвлөх ажиллуулсан,

Бусад тээврийн хэрэгслээс ялгарах цэнхэр өнгийн дугаар аваагүй тээврийн хэрэгсэл төсвийн байгууллагуудад ашиглагдаж байна

1.1.4 Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгслийн хязгаарлалтай холбоотой 2.3 сая төгрөгийн 4 зөрчил илэрсэн нь аймгийн ЗДТГ 2023 онд албан тушаалын тээврийн хэрэгсэл унах эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл унасантай холбоотой 2.3 сая төгрөгийн албан шаардлага, тээврийн хэрэгсэлд цэнхэр өнгийн дугаар аваагүйтэй холбоотойгоор 3 байгууллагад зөвлөмжийг хүргүүлсэн байна.

1.1.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4³ дахь заалт, ЗГ-ын 2022 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлсэн эсэхэд нийт 99 авто тээврийн хэрэгслийг түүвэрлэн хянахад түүвэрт хамрагдсан 99 тээврийн хэрэгслээс 40 тээврийн хэрэгсэл цэнхэр өнгийн дугаар аваагүй байна.

1.1.6 Цэнхэр дугаар аваагүй 40 тээврийн хэрэгслээс эвдэрсэн 3, актлах санал хүргүүлсэн 2 тээврийн хэрэгсэл байна.

1.1.7 Аймаг, сумын ИТХ нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Аудитын илрүүлэлт

¹ Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно

² Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно

³ Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ

- *Аймаг, сумын ИТХ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1⁴-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс ОНӨААТҮГ-ын ТУЗ нь байгууллагын удирдах ажилтан болон албан тушаалтнуудын цалинг харилцан адилгүй 0,8- 2.5 сая төгрөгийн цалин тогтоосон*

Хуулийн зөвшөөрөөгүй бусад хангамжийн зардалд 2023 онд 88.5 сая, 2024 онд 614.6 сая төгрөгийн үрэлгэн зардлыг санхүүжүүлжээ

1.1.8 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн төрийн байгууллагууд гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлээгүй байна.

1.1.9 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн зардлын хязгаарлалттай холбоотой 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 88.5 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөн нь аймгийн ИТХ нь байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй 7.2 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн, төлөөлөгч нар гадаад улсад туршлага судлахаар 80.0 сая төгрөгөөр явсан, Хар нуур, ховд голын сав газар болон Буянт сумын соёлын төв нь байгууллагын албан хэрэгцээнд хамааралгүй 1.4 сая төгрөгийн бараа материал худалдан авсан зөрчлүүдэд зөвлөмж өгөгдсөн байна.

1.1.10 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн ИТХ нь өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй дахин төлөөлөгч нарыг гадаад улсад туршлага судлуулахаар 231.0 сая төгрөгийг зарцуулсантай холбоотойгоор 1 албан шаардлага бичигдсэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль тогтоомжийг зөрчин 101.9 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

1.1.11 Санхүүгийн тайлангийн аудитаар 2024 онд Аймгийн ЗДТГ-ын сонгуулийн шинж чанартай сэтгүүл болон сонин захиалсан, худалдан авах ажиллагаа зарлахгүйгээр задалж худалдан авалт хийсэнтэй холбоотой 147.8 сая төгрөгийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шилжүүлсэн, мөн төрийн албан хаагчдыг гадаад улсад 115.5 сая төгрөгөөр аялуулсан тул зөвлөмж өгөгдсөн.

1.1.12 Алтай сумын ЗДТГ нь сумын 100 жилийн ойд 3.4 сая төгрөгийг зарцуулсан, Чандмань сумын ЗДТГ нь байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй 3.0 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн, Дуут сумын ЗДТГ нь ИТХ-д тавилга худалдан авахад 3.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Хэмнэлтийн бусад арга хэмжээг зарим байгууллага хэрэгжүүлээгүй, Төсвийн шууд захирагч нь бусад шууд захирагчдаа урамшуулал олгон ажиллах талаар албан бичиг явуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцэхгүй байна

1.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3⁵ дахь заалтыг зөрчин 2023 онд 113.2 сая төгрөгийн 36 зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрч, урамшууллыг зөрүүтэй олгосонтой холбоотой 67.7 сая төгрөгийн 26 төлбөрийн акт тогтоож, 38.8 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 16.7 сая төгрөгийн 7 зөвлөмжийг хүргүүлжээ.

1.2.2 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх заалтыг зөрчсөнтэй холбоотой 621.5 сая төгрөгийн 54 зөрчил илэрч, урамшууллыг зөрүүтэй олгосонтой холбоотой 115.5 сая төгрөгийн 25 төлбөрийн акт тогтоож, 199.1 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 306.9 сая төгрөгийн 24 зөвлөмжийг хүргүүлжээ.

⁴ Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно

⁵ Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох

1.2.3 Урамшуулалтай холбоотой зөрчил 2024 онд өсөх болсон шалтгаан нь аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 2/1865 тоот албан бичиг болон аймгийн Засаг даргын Б/40 тоот захирамжаар төсвийн шууд захирагчид байгууллагынхаа ажилтан, албан хаагчдад хуульд заагаагүй мөнгөн урамшуулал олгосон нь голлох нөлөө үзүүлсэн байна.

1.2.4 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд аймгийн контент хийлгэх 120.0 сая төгрөгийг төсөвт өртөгтэй ажлыг худалдан авах ажиллагаа зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4⁶ дахь заалттай нийцээгүй тул ТЕЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмжийг хүргүүлсэн байна.

1.2.5 Чандмань сум ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд сумын 100 жилийн ойтой холбоотой аялал жуулчлалыг татах бичлэг хийлгэхэд 40.0 сая төгрөгийг мөн санхүүжүүлсэн тул алдааг давтан гаргахгүй байх албан шаардлагыг ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлжээ.

1.2.6 Сумдын ЗДТГ-ууд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5⁷ дахь заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд 15.9 сая төгрөгийн зөвлөмж, 2024 онд 2.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт бичигдэж 9.5 сая төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлжээ.

1.2.7 Эрүүл мэндийн салбарын байгууллагууд нь 2024 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6⁸ дахь заалтыг мөрдөн ажиллаагүйгээс 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөрчил илэрч зөвлөмж хүргүүлж байсан бол 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 267.5 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж 15.9 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлжээ.

1.2.8 Тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8⁹ дахь заалтыг зөрчин биеийн тамирын уралдаан тэмцээний зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар Хүнс, хөдөө аж ахуйн газар 4.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж өгөгдсөн бол 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Дуут сумын ТТЗ 3.4 сая төгрөгийг зарцуулсан тул зөвлөмж өгөгдсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх заалтыг хэрэгжүүлээгүй байна

1.2.9 Тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹⁰ дахь заалтыг хэрэгжүүлэхээр аймгийн төсвөөс 2022 онд дулааны тоолуурыг худалдан авч Жаргалант сумын 16 цэцэрлэгүүдэд суурилуулжээ. Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 174 тоот тогтоолоор “Ховд дулааны станц” ТӨХК-ийн дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн баталсан байна. “Ховд дулааны станц” ТӨХК-иас 34 төсөвт байгууллага халаалт авч байгаагаас 9 байгууллага нь дулааны тоолууртай ч 2023, 2024 онд 1 байгууллага дулааны тоолуураар хэрэглэсэн дулааны төлбөрөө төлсөн бусад байгууллагууд нь тогтмол дүнгээр төлж байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

⁶ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх

⁷ төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах

⁸ нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх

⁹ байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах

¹⁰ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх

1.2.10 Шим-Ус ОНӨААТҮГ-аас аймгийн төв болон Алтай, Зэрэг, Мянгад сумын төсөвт байгууллагууд цэвэр ус авч бохир ус зайлуулах гэрээг байгуулан ажиллаж байна. Тус байгууллагаас цэвэр усны тоолууртай төсөвт байгууллага байхгүй байна.

1.2.11 Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5¹¹ дахь заалтад заасны дагуу өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө гаргаагүй зөрчил санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байна. 2023 онд 4 байгууллагатай холбоотой 1,215.8 сая, 2024 онд 5 байгууллагатай холбоотой 756.0 сая төгрөгийн зөвлөмжийг хүргүүлжээ.

БҮЛЭГ 2: ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ ХУУЛИАР ХОРИГЛОСОН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛДЭГ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХГҮЙГЭЭР ТӨСӨВТ ӨРТГИЙГ ЖИЖИГЛЭСЭН ЗӨРЧИЛ АРИЛАХГҮЙ БАЙНА

ОНХС-гийн хөрөнгөөр хуулиар хориглосон арга хэмжээг санхүүжүүлжээ

2.1.1 Аймгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хязгаарлалтай холбоотой 557.0 сая төгрөгийн 23 зөрчил илэрснээс 72.9 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож 245.1 сая төгрөгийн 6 албан шаардлага бичигдэж 239.0 сая төгрөгийн 13 зөвлөмж өгч шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.

2.1.2 Аймгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хязгаарлалтай холбоотой 730.3 сая төгрөгийн 13 зөрчил илэрснээс 103.7 сая төгрөгийн 3 албан шаардлага бичигдэж 626.6 сая төгрөгийн 10 зөвлөмж өгсөн байна.

2.1.3 ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3¹² дахь заалтыг зөрчин хэмнэлтийг аймгийн ОНХС-гийн дансанд төвлөрүүлээгүй тул 41.4 сая төгрөгийн төлбөрийн акт, Эрдэнэбүрэн сумын ТТЗ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар хөшөө хийсэнтэй холбоотой 4.0 сая төгрөгийн төлбөрийн акт бичигджээ.

2.1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5¹³ дахь заалтыг зөрчин төсөвт өртгийг 607.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн их засварын ажлыг 429.1 сая төгрөгөөр төсөвт батлуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч ажлыг гүйцэтгэх явцад ажлын тоо хэмжээг нэмэгдүүлж төсөвт өртгийг 183.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Спортын ордны засварын ажлыг 288.0 сая төгрөгөөр төсөвт батлуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч ажлыг гүйцэтгэх явцад ажлын тоо хэмжээг нэмэгдүүлж төсөвт өртгийг 423.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн,

2.1.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1¹⁴ дахь заалтыг зөрчин 78.6 сая төгрөгийн хөшөө, дурсгал, угтах үдэх хаалга хийх болон засварлахад 52.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал:

Аудитын илрүүлэлт

¹¹ хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх

¹² хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх

¹³ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх

¹⁴ хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах

- Ховд сум 2024 онд ОНХС-гийн хөрөнгөөс 5.0 сая төгрөгийг гэрэлт хөшөө хийхэд зарцуулсан,
- Үенч сум нь ОНХС-гийн хөрөнгөөр 5 хошуу малын хөшөө хийлгэх ажилд 2023 онд 30.0 сая, 2024 онд 20.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн,
- Үенч сум ОНХС-аас Амарсанаагийн цэнгэлдэх хүрээлэнд 14.3 сая төгрөгөөр хөшөө хийлгэхэд санхүүжүүлсэн,
- ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд Цэцэг сум угтах хаалга хийлгэхэд 40.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн,
- Буянт сум 2023 онд үдэлтийн талбайн засварыг ОНХС-гийн хөрөнгөөс 12.9 сая төгрөгийг санхүүжүүлсэн,
- Мянгад сум 2023 онд Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнд хөшөө хийлгэхэд 9.3 сая төгрөгийг ОНХС-гийн хөрөнгөөс санхүүжүүлсэн,

2.1.6 УТХО-аар 2023 онд Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Ховд аймагт 2,200.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулах эрхийг шилжүүлж аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/266 тоот захирамжаар 12 багц болгожээ. Тус хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим багцын төсөл арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1¹⁵ дахь заалтыг зөрчин 978.5 сая төгрөгийг гудамж талбайн тохижилт, гэрэлтүүлэг хийхэд зарцуулсан байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- Зэрэг суманд 299.9 сая төгрөгөөр гудамж талбайн тохижилт хийх ажлыг санхүүжүүлсэн,
- Манхан суманд 200.0 сая төгрөгөөр гудамж талбайн тохижуулах ажлыг санхүүжүүлсэн,
- Чандмань суманд 79.8 сая төгрөгөөр гэрэлт цамхаг болон гудамжны тохижилт, гэрэлтүүлэг хийх ажлыг санхүүжүүлсэн,
- Цэцэг суманд 199.8 сая төгрөгөөр авто зогсоол болон тохижилтын ажлыг санхүүжүүлсэн,
- Жаргалант суманд 49.2 сая төгрөгөөр Жаргалан багын тоглоомын талбай тохижуулах ажлыг санхүүжүүлсэн,
- Буянт суманд 149.8 сая төгрөгөөр нийтийн эзэмшлийн талбай тохижуулах ажлыг санхүүжүүлсэн,

2.1.7 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5¹⁶ дахь заалтыг зөрчин иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг ОНХС-аас санхүүжүүлсэн байна. Санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд 511.7 сая төгрөгийн 21 зөрчил илэрснээс 27.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 245.1 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 239.1 сая төгрөгийн 13 зөвлөмж өгөгдсөн бол 2024 онд 109.6 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж 229.7 сая төгрөгийн 7 зөвлөмж өгч ажиллажээ.

Босго үнээс давсан ажлыг онцгой комиссын шийдвэр гарган шууд худалдан авдаг, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр төсөл арга хэмжээг жижиглэн баталсан зөрчил буурахгүй байна

2.2.1 Аймгийн төсөвт болон төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр заалтыг зөрчин 2,304.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 38.2 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж 2,266.4 сая төгрөгийн 8 зөвлөмж өгөгдсөн байна.

¹⁵ орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалд, гэрэлтүүлэг, тохижилт

¹⁶ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ

2.2.2 Аймгийн төсөвт болон төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр заалтыг зөрчин 1,814.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 47.4 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж 1,767.1 сая төгрөгийн 19 зөвлөмж өгөгджээ.

2.2.3 Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4¹⁷ дахь заалтыг зөрчин цахим дэлгүүрт байршсан хөрөнгийг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг 2023 онд Онцгой байдлын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Цагдаагийн газар, 2024 онд Жаргалант сумын 14-р цэцэрлэг, Манхан сумын сургуулиудад гарсан тул зөвлөмжийг өгсөн байна.

2.2.4 Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.5¹⁸ дахь заалтыг зөрчин 2023 онд Жаргалант сумын 1-р цэцэрлэг болон Ховд сумын сургууль, 2024 онд Дуут, Буянт, Үенч, Жаргалант сумын 1, 8, 11-р цэцэрлэгүүд, Буянт, Үенч, Мөст, Эрдэнэбүрэн, Булган сумын Минжит булган цогцолбор сургуулиуд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Мөст сумын Засаг дарга, Хот тохижуулах газар нь босго үнээс давсан ажлуудад худалдан авах ажиллагаа зарлаагүй бол 2023 онд Эрдэнэбүрэн, Алтай, Буянт сум, 2024 онд Ховд аймаг дахь анхан шатны шүүхийн тамгын газар, Алтай, Үенч сумын ОНХС нь худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас зайлсхийж төсөвт өртгийг хувааж хэд хэдэн төсөл арга хэмжээ болгон баталжээ. Жаргалант сумын ЗДТГ нь аймгаас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхдээ сумын онцгой комиссын шийдвэр гаргуулан 2023 онд шууд гэрээ байгуулсан, 2024 онд Онцгой байдлын газар нь мөн онцгой комиссын шийдвэрээр шууд худалдан авалт хийсэн байна.

БҮЛЭГ 3: ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНГ ТООЦООГҮЙ, ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд хяналтыг хэрэгжүүлсэн байна

3.1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1¹⁹-д заасны дагуу хяналтыг Төрийн аудитын байгууллага, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага хийхээр хуульчилсан байна.

3.1.2.Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагаас 2023 болон 2024 онд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд гарсан зөрчил нь өмнөх оноос 658.4 сая төгрөгөөр өссөн байна.

3.1.3 Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 онд 69 байгууллагад санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэн 2023, 2024 онуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг бие даан хэрэгжүүлээгүй төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг хэрэгжүүлэхдээ хуулийн хэрэгжилтийг хянасан байна.

3.1.4 Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс төсөвт байгууллагуудын гүйлгээнд цахимаар хяналтыг хэрэгжүүлэн ажиллажээ.

¹⁷ Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно

¹⁸ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана

¹⁹ Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана.

3.1.5 Санхүү төрийн сангийн хэлтэс нь 2023-2024 онуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хяналт шалгалт хийгээгүй ч, аймгийн санхүү бүртгэлийн ажилтныг чадавхжуулах сургалтыг зохион байгуулан ажиллажээ.

3.1.6 Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 1/1899 тоот албан бичгээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах талаар сум байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны хүрээнд 2023, 2024 онуудад нийт 5,398.0 сая төгрөгийн хэмнэлт бий болжээ

3.2.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлээр 82,500.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 68,508.5 сая төгрөгийн зарцуулж 13,991.8 сая төгрөгийн хэмнэлттэй, 2024 санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлээр 131,377.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 110,585.4 сая төгрөгийн зарцуулж 21,791.6 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

3.2.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2024 онд 21,791.6 сая төгрөгийг зарцуулаагүй байгаа ч хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс 2,421.4 сая төгрөг нь худалдан авах ажиллагааны хүрээнд бий болсон хэмнэлт, 14,337.4 сая төгрөг нь тайлант онд бүрэн хэрэгжиж дуусаагүй болон хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын ажлуудын зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

3.2.3 Урсгал зардлыг 2023 онд 4,647.9 сая, 2024 онд 5,032.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь бараа үйлчилгээний бусад зардлыг 2023 онд 2,222.8 сая төгрөгөөр, тогтмол зардлыг 780.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан, 2024 онд бараа үйлчилгээний бусад зардлыг 2,114.6 сая, тогтмол зардлыг 729.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь зарим байгууллагуудын төлөвлөлтийг хангалтгүй хийсэнтэй байгаатай холбоотой байна.

3.2.4 Улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 65 төсөл арга хэмжээний 19,390.9 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Гүйцэтгэлээр 62 төсөл арга хэмжээнд 17,452.3 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 3 төсөл арга хэмжээний 1,118.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа амжилтгүй болж 820.6 сая төгрөгийг хэмнэсэн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын дуусаагүй 8 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох 1,640.1 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулжээ.

3.2.5 Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 127 төсөл арга хэмжээний 128,122.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 38,071.2 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ нь хуулийн байгууллагад шалгагдаж, 6 төсөл арга хэмжээний 2,090.6 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа амжилтгүй болж 4,577.4 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын дуусаагүй 25 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болох 7,637.7 сая төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

3.2.7 Эдгээр хөтөлбөр арга хэмжээний үйл ажиллагаанаас 2024 онд 3,328.5 сая төгрөгийн ажил зарлагдаагүй, хэрэгжээгүй нь тухайн жилийн *төлөвлөлтийг* үнэн зөв тооцоолж төлөвлөөгүйгээс хэрэгцээт төсөл арга хэмжээнүүд явагдахгүй үлдсэн, сум орон нутагт эрх нь шилжсэн зарим төсөл арга хэмжээнүүдийн батлагдсан төсөвт өртөг нь буурч улмаар хөрөнгө оруулалт чанартай хэрэгжих, зарцуулалтад хэмнэлт гарахад нөлөөлж байна.

3.2.8 Аймгийн ИТХ даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн А/08 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар 18 тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулахаас 12 машиныг дуудлага худалдаанд борлуулж төсөвт 106.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд 4 автомашин оролцогч ирээгүй тул хойшлуулсан,

3 авто машин авахаас татгалзсан, тогтоолын 3 дугаар хавсралтаар 13 автомашиныг автомашин дутагдалтай төсөвт байгууллагуудад балансаас баланст шилжүүлжээ.

3.2.9 2024 онд ИТХ-ын даргын 2024 оны 07 дугаар сарын 26-ний өдрийн А/61 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар 33 тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулахаас 22 машиныг дуудлага худалдаанд борлуулж төсөвт 160.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд 11 автомашин оролцогч ирээгүй тул хойшлуулжээ.

- 2023 онд Ойн ангийн дуудлагаар худалдах 7272ХОУ улсын бүртгэлтэй Пургон авто машиныг худалдах доод үнийг 3.5 сая төгрөгөөр тогтоосон байхад аймгийн Худалдан авах газрын даргын тушаалаар доод үнийг 3,0 сая төгрөг болгон бууруулан үнийг нь зарласан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 27-ний өдрийн 467 дугаар тогтоолын 1.1 дахь заалтыг зөрчсөн
- Ховд аймгийн Жаргалант, Алтай, Булган, Зэрэг сумын Засаг даргын тамгын газрууд, Эрүүл мэндийн төвүүд, Цагдаагийн газар, Шим-Ус ОНӨААТҮГ-уудын нийт 10 тээврийн хэрэгслүүдийг дахин дуудлага худалдааг зохион байгуулаагүй, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын дагуу татан төвлөрүүлэх, тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- 2023 онд Дуудлага худалдаанд оролцогчийн төлсөн дэнчинг өөр оролцогчийн төлбөрийн үнийн дүнд суутган тооцохдоо баримтгүйгээр суутгасан, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн маяггүйгээр дуудлага худалдаанд оролцсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтыг зөрчиж байна.

3.2.10 Аймгийн хэмжээнд 4 ТӨҮГ, 9 ОНӨҮГ бүртгэлтэй байгаа хэдий ч ТӨҮГ-ууд нь ТУЗ-өөр хэлэлцэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон зорилтод түвшинг баталж ажиллаж байна.

3.2.11 Шим-Ус ОНӨААТҮГ нь ТУЗ-аараа эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлуулан ажиллаж байгаа бол бусад ОНӨААТҮГ нь ТУЗ-аараа эдийн засгийн зорилтот түвшинг батлуулаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3²⁰-д заасан мэдээллийг цахим хуудсанд ил тод мэдээлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Шилэн дансны үйл ажиллагаанд орон нутгийн ИТХ болон ИНХ хуульд заасан хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна

3.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²¹ дахь заалтын хүрээнд 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 48.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, 13 байгууллагад 279.5 сая төгрөгийн зөрчил арилгах зөвлөмж өгч ажилласан бол 2024 онд 1 албан шаардлага, 23 зөвлөмж өгч ажиллан зөвлөмжийн хэрэгжилтийг төрийн аудитын байгууллагын fas.audit.mn программаар хянан ажилласан.

3.3.2 Нийцлийн аудитаар аудитын түүвэрт ЭМ-ийн салбарын 15, боловсролын салбарын 8, соёлын салбарын 20, орон нутгийн 9 байгууллага нийт 52 байгууллагад горим сорил хэрэгжүүллээ.

3.3.3 Түүвэрт хамрагдсан байгууллагууд 2023 онд 248 мэдээлэл, 2024 онд 237 мэдээллийг хуулийн хугацаа хоцроон байршуулжээ. 2023 онд хуулийн хугацаанд мэдээлээгүй 366 мэдээлэл байсан бол 2024 онд 5 болж буурсан үзүүлэлттэй байна.

3.3.4 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас улирал тутам орон нутгийн байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянаж байгаа бөгөөд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1.3²²-д дахь заалт, 10 дугаар зүйлийн

²⁰ Энэ хуулийн 15.4-т заасан гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.

²¹ Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна

²² тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан.

10.1²³-дэх заалтын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллах эрх бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцон ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн боловч тус зөвлөмжийн хэрэгжилтийг тооцон ажиллаагүй байна.

3.3.5 Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1²⁴-д заасны дагуу аймаг, сумдын ИТХ бол иргэдийн Нийтийн Хурлаас хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Шат шатны төсвийн захирагч нар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
2. Аймгийн ИТХ нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс ОНӨААТҮГ-ын захирал болон албан хаагчид харилцан адилгүй цалин авч байна.
3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зарим төсөвт байгууллагын удирдлага нар хэрэгжүүлээгүйгээс цэнхэр өнгийн дугаар аваагүй 40 тээврийн хэрэгсэл ашиглагдаж байна.
4. Хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулаагүй, төсвийн шууд захирагч нь өөрт хамааралгүй асуудлаар албан бичиг бусад байгууллагад явуулсан нь хуулийн шаардлагыг хангахгүй байна.
5. ОНХС-гийн хөрөнгөөр хуулиар хориглосон төсөл арга хэмжээг баталж санхүүжүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг үр өгөөжийг бууруулж байна.
6. Цэвэр ус, түлш халаалтын зардалд хэмнэлт бий болгох талаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудын үр дүн гараагүй байна.
7. Шилэн дансны тухай хуульд заасан чиг үүрэг бүхий байгууллагууд хяналтыг үр дүнтэй зохион байгуулаагүйгээс хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

**АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА З.ЭРХБАЯРТ
ТОЛИЛУУЛАХ НЬ:**

1. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын цалингийн жишиг нормыг тогтоон ажиллах
2. Шилэн дансны тухай хуульд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА М.АМАРСАНАА ТАНАА:

1. ОНХС-гийн хуулиар хориглосон төсөл арга хэмжээг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулах
3. Нэгдсэн дулаан, цэвэр ус авч байгаа төсөвт байгууллагуудыг тоолууржуулах ажлыг зохион байгуулж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэн цэвэр ус, дулааны хэрэглээг хэмнэж ажиллах.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА:

1. Цэнхэр дугааргүй тээврийн хэрэгслийн талаарх судалгааг гаргаж дугаар солих ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах
2. Дуудлага худалдаанд оролцогчийн төлсөн дэнчинг өөр оролцогчийн төлбөрийн үнийн дүнд суутган тооцохдоо баримтгүйгээр суутгасан, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн маягтгүйгээр дуудлага худалдаанд оролцдог явдлыг таслан зогсоож, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтыг мөрдөж ажиллах

3. Дуудлага худалдааг зохион байгуулаагүй тээврийн хэрэгслийн дуудлага худалдаанд оруулж орлогыг төсөвт төвлөрүүлэн ажиллах

**АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА
Н.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА:**

1. Дуудлага худалдаагаар худалдах төрийн өмчийн хөдлөх үндсэн хөрөнгийн худалдаалахаар санал болгох доод үнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 27-ний өдрийн 467 дугаар тогтоолын дагуу тогтоон мөрдөж ажиллах.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАРТ
ХҮРГҮҮЛЭХ САНАЛ**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим заалтуудыг хэрэгжүүлэхэд төсвийн захирагч нарт хүндрэл тулгарч байгаа тул хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг УИХ-д толилуулах шаардлагатай байна. Тухайлбал.

1. Хөдөө орон нутаг худалдан авах ажиллагаанд оролцогч ААН-ын тоо цөөн, тул дахин зарлагдаг, төсөв бага ч ажлын тоо хэмжээ их тул төлөвлөсөн хугацаанд хэрэгжилт хангагдахгүйгээс хөрөнгө оруулалтын ажлууд хэрэгжихгүй, төсөв татагдах эрсдэл үүсэхээр

байна. Иймд хуулийн 13.1.1 заасан батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах заалтыг хугацааг сунган нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байна.

2. Хуулийн 15.1.8 -д заасан заалт нь Биеийн тамир спортын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх үүрэг, холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.
3. Хуулийн 13.3.2-д заасан улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй хөрөнгө хөрөнгө оруулалт хийх зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгардаг. Тухайлбал: Нийтийн эзэмшлийн байр орон сууцны засвар үйлчилгээ, шугам сүлжээний засварт ОНХС, ОНХО-аар иргэдийн саналаар эрэмбэлэгдэн аймгийн ИТХ-аар батлан төсөл арга хэмжээг санхүүжүүлж байна.

Аймгийн Засаг дарга нь 2024 оны 12 дугаар сараас эхлэн 2 орлогчтой ажиллаж байгааг анхаарч аймгийн Засаг даргыг томилсон албан тушаалтанд хүргүүлэх шаардлагатай байна.